

22. Эзэн минь, шинэ үйлчилгээний хөтөлбөр зохиож буй Португалийн TWR-н “Найдвар доторх Эмэгтэйчүүд” багт нигүүлсэл, мэргэн ухаан, бүтээлч сэтгэлгээг өгөөч. (Сургаалт үгс 2:6).

23. Бурхан минь, Польш эмэгтэйчүүдийн нийгмийн байр суурь, сайн сайхан байдал, хууль эрх зүйн аюулгүй байдлыг хамгаалахыг танаас хүсэж байна. Тэдний хамгаалагч, хангагч бай. (Дуу. 5:11)

24. Аав аа, бид Хойд Кавказын хэцүү гэрлэсэн /хулгайлах буюу хүчээр гэрлэсэн ёс/ TWR-н “Найдвар доторх Эмэгтэйчүүд” сонсогчдод мэргэн ухааныг гуйж байна. Тэд таны хайранд итгэл найдвар олох болтугай. (Иаков 1:12)

25. Эзэн минь, 2022 онд Германы TWR-н “Найдвар доторх Эмэгтэйчүүд” залбирлын цугларалт амжилттай болж, тус яамыг санхүү болон залбирлаар дэмжсэн хүмүүст баярлалаа. (Мал. 3:10)

26. Аав аа, Финлянд сэтгэлээр унасан, ганцаардсан хүмүүст өөрийнхөө үнэнийг эргэцүүлэн бодоход нь тусалж, тэд ганцаараа биш гэдгийг мэдрүүлээрэй. Тэдэнд тусалж чадах хүмүүс, нөөц боломжтойн холбогдоход нь туслаач. (Дэд хууль 31:8).

27. Бурхан минь, Гренланд дахь оюутнуудын дунд Христийн шашны ажлыг хөгжүүлээч. Эдгээр залуучуудыг Библи уншиж, дэмжлэг авах боломжтой Христийн нийгэмлэгтэй болгоорой. (1 Тесалоник 5:11).

28. Эзэн минь, Дани дахь TWR-ийн “Найдвар доторх Эмэгтэйчүүд” жижиг багийг үйлчлэлд нь дэмжиж, урам зориг өгөхийг бид танаас хүсэж байна. (Филиппой 4:13).

29. Тэнгэрлэг Эцэг минь, Хорват дахь өрх толгойлсон эхчүүд хуучин нөхрөөсөө байнгын дэмжлэг авч байгаасай гэж бид залбирдаг. (Матай 7:9)

30. Эзэн минь, энэ харанхуй ертөнцөд гэрэл гэгээтэй байхын тулд Албанийн сүмийг хүчирхэгжүүлээч. Тэднийг бурханлаг, үр бүтээлтэй амьдрахад нь туслахын тулд эмэгтэйчүүдтэй нэгдээрэй. (Еф. 5:8)

후원안내

국민은행 851-01-0003-724 북방선교방송

최초 입금 후 사무실로 연락 주시기 바랍니다



Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 65,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



**2023. 4.**

**Европ эмэгтэйчүүдын төлөөх залбирал2.**

Эмэгтэй хүн бүр өөрийг нь бүтээсэн Бурхан өөрийг нь хэр эрхэмлэн үзэж, өөрт нь ямар гайхалтай төлөвлөгөөтэй байгааг мэдэх эрхтэй. Есүстэй уулзаж, Түүний гайхалтай хайрыг мэдэрсэний дараа эмэгтэйчүүд хэрхэн хувирч байгааг харах шиг сайхан бөгөөд сэтгэл хөдөлгөм зүйл байхгүй.

**TWR Korea 북방선교방송**

서울특별시 관악구 양녕로 15, 월드빌딩 6층  
전화 (02)886-5671 / 이메일 phkorea@twrk.or.kr

1. Эзэн минь, Шведэд амьдрал ямар ч учир утгагүй мэт санагдаж буй ганцаардмал хүмүүст өөрийгөө илчин харуулаач. Тэдэнд улам ганцаардах мэдрэмжийг төрүүлж байгаа зүйлсээс зайлсхийхэд нь туслаач. (Дуу. 36:9)

2. Испанид цагаач эмэгтэйчүүдийн тоо сүүлийн 10 жилд асар их өссөн. Аав аа, тэднийг сексийн наймаанаас хамгаалж, амьдралын чанарыг нь сайжруулж өгөөч. (Дэд хууль 10:18–19)

3. Бурхан минь, залуу эмэгтэйчүүд, окидоос хэвлэл мэдээллийн сөрөг нөлөөлөл тасрах болтугай. Сербийн TWR-н “Найдвар доторх Эмэгтэйчүүд” үйлчлэлийг ашиглан залуучуудад таны доторх өөрийнхөө жинхэнэ дүр төрхийг олж мэдэхийг зааж өгнө үү. (Езек. 36:26–27)

4. Аав аа, TWR-н “Найдвар доторх Эмэгтэйчүүд” хөтөлбөрийг бичиж байхдаа Румыны багийнханд урам зориг, мэргэн ухааныг өгөөч. Хөтөлбөрийн агуулга утга учиртай, найруулга сайтай, сонсогчдод таныг илүү их хайрлаж, таньж мэдэхэд нь туслах болтугай. (Дуу. 40:10)

5. Бурхан аав аа, хүмүүс боломжийн үнээр хоол хүнс худалдан авах боломжтой байхын тулд Португалийн эдийн засгийн хүнд байдлыг хэвийн байдалд оруулаач. (Мат. 6:25)

6. Гренландад хүүхдүүдийн 37% нь эцэггүй амьдарч байна. Хүүхдээ харах, ажил хийх, суралцах гээд бүгдийг хослуулан авч ёстой өрх толгойлсон эхчүүдийг хүчирхэгжүүлээч. Эдгээр хүүхдүүдийг Бурханлаг эрэгтэй зөвлөгчөөр хангаач. (Дуу. 69:5)

7. Эзэн минь, Польшийн эмч нарыг илүү өндөр цалинтай ажил хайж цагаачлуулахгүйн тулд эмнэлгийн үйлчилгээг сайжруулах, цалин хөлсийг нэмэгдүүлэх талаар Польшийн

удирдагчдад мэргэн ухааныг өгөөч. (Иаков 1:5)

8. Бурхан минь, бид Норвеги дахь TWR-н “Найдвар доторх Эмэгтэйчүүд” сайн мэдээг илүү олон хүрч чадаагүй бүлэг хүмүүстэй хуваалцахын тулд илүү их санхүүжилт хүсэж байна. (Марк 16:15)

9. Эзэн минь, маш их Албани эмэгтэйчүүд сэтгэлийн хямралд орж, шаналж байна. Тэд Таныг дуудах үед тэдний оюун ухаан, бие махбодод эдгэрлийг авчраач. Тэднийг тусалж чадах хүмүүст хүргээч. (Дэд хууль 31:8).

10. Хойд Кавказад олон нийтийн сүлжээний хориг тавьсны улмаас өөр платформ дээр гарч буй “Найдвар доторх Эмэгтэйчүүд” хөтөлбөрт шинэ үзэгчдийг нэмэгдүүлж өгнө үү. (2 Коринт 4:16)

11. Хүчирхэг Аав аа, Германд биеэ үнэлж буй эмэгтэйчүүдийг далд эрдэнэсийн аудио цувралыг сонсож Есүс дотор аюулгүй байдал, шинэ амьдралыг олж мэдэх болтугай. (Ис. 45:3)

12. Хэт их ажил, гэр бүлийн үүрэг хариуцлагаас болж сэтгэлээр унасан Финландын эмэгтэйчүүдэд хүч чадал, урам зориг хайрлаач, Бурхан минь. (Матай 11:28)

13. Эзэн минь, Гренланд, Фарерын арлууд дахь эцэг эхийн архинд донтсон гинжин хэлхээг таслаач. Тэд хүүхдүүдээ Бурханлаг байдлаар өсгөх болтугай. (Сур. 22:6)

14. Бурхан минь, 4-р сарын 14-16-нд болох Норвегт болох TWR-ийн “Найдвар доторх Эмэгтэйчүүд” чуулга уулзалтад оролцох эмэгтэйчүүдээ урам зориг өгч, таны ажилд илүү идэвхтэй оролцох болтугай. (1 Тес. 5:11)

15. Аав аа, Даничууд амьдрал ямар үнэ цэнтэй, хүүхдүүд бол бурхнаас ирсэн бэлэг гэдгийг ойлгоосой гэж бид залбирч байна. (Дуу. 139:13–16)

16. Хорват дахь TWR-ийн “Найдвар доторх Эмэгтэйчүүд” фейсбүүк хуудсыг дагагчдын тоо болон харилцан үйлчлэлийн тоо өссөөр байгаад Бурхан минь таныг магтъя. (Дуу. 71:8)

17. Эзэн минь, гэр бүлийн хүчирхийллийн улмаас хамгаалах байраа орхиж, үр хүүхдээ өсгөх мөнгөгүйн улмаас биеэ үнэлж буй Албани эмэгтэйчүүдэд ажил, байр олгож өгөөч. (Матай 6:11)

18. Аав аа, Шведийн залуу гэмт хэрэгтнүүд танд итгэн таныг дагах болтугай. Өөрийнхөө болон бусдын амьдралыг сүйтгэхээ больж, ухааран ойлгох зүрхийг өгөөч. (Марк 1:17)

19. Гэр бүлийн хямрал эсвэл салалтын улмаас асран хамгаалагч болсон Испани дахь Христийн шашинтай өвөө, эмээ нар ач зээ нартаа бурханлаг библийн нөлөө үзүүлэн үлгэрлэхэд нь Бурхан та туслаарай. (Дэд хууль 6:6–7)

20. Аав аа, "Precious and Beloved" нэвтрүүлгийн орчуулга, найруулга дээр ажиллаж байгаа хүмүүсийг чиглүүлээрэй. Серби, Хорватын эмэгтэйчүүд энэ хөтөлбөрөөр дамжуулан таны хайрын тухай мэдэж, өөрсдийн эрхэм чанар, үнэ цэнийг танаас олж мэдэх болтугай. (1 Петр 3:4)

21. Бурхан минь, энэ хэцүү цаг үед Румын дахь Христэд итгэгч эмэгтэйчүүдийг таны төлөө үнэнч гэрч байхын тулд хүчирхэгжүүлээрэй. (Мат. 5:13–16)